

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2020 он)

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202003/01. ИНЕГ-т; Харилцаа холбооны зохицуулах хороонд. /Safety recommendation 202003/01. МСАА; ХХЗХ/.

Чикагогийн Конвенцийн Хавсралт 10 Aeronautical Telecommunications, V-р боть, 4.1.Utilization of frequencies above 30 MHz, *“The need to provide for coordination between international and national utilization so as to ensure mutual protection from interference”*; Радио долгионы тухай Монгол Улсын хуульд заагдсан долгионы давтамжийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах талаар тус тус заагдсан боловч иргэний нисэхийн салбарт хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна. Иймд ИНЕГ нь Харилцаа Холбооны Зохицуулах Хороотой “иргэний нисэхийн радио холбооны давтамж (117,975 – 137,000 МГц)-ийн ашиглалт, хамгаалалт”-ын талаар эрх зүйн зохицуулалтыг хийж хэрэгжилтийг хангах.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202003/02. ИНЕГ-т . /Safety recommendation 202003/02. МСАА/.

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгж, секторын ажлын байрны Агаар-газар ангилалын радио холбооны давтамж дахь шуугианы нөлөөллийг багасгах, аюулгүй ажиллагааг дээшлүүлэх зорилгоор Чикагогийн Конвенцийн Хавсралт 10, Volume V - Aeronautical Radio Frequency Spectrum Utilization болон ИКАО-ын DOC 9718 Volume II - Frequency assignment planning criteria for aeronautical radio communication and navigation systems-ын дагуу радио холбооны давтамжийн хувиарлалт /офсет давтамж/-ын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангах.